



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны ээлжит 02 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 01 дүгээр хуралдаан 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 02 дугаар хуралдаанаар /2026-01-30/ “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан”-гийн танилцуулга (Газар бүрээр); “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-ын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтийн тухай (Хорооны 2025 оны 249 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); “Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогдод радио өргөн нэвтрүүлгийн радио давтамжийн тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарлах тухай”; ХХЗХ-ны 2025 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогын үр дүн, хөрөнгө актлах, хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоох, ашиглалтын хугацааг сунгах тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл олгосноос хойш 2 жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй үйлчилгээ эрхлэгчдийн танилцуулга, хэрэгжүүлэх арга хэмжээний тухай-ТЗ түдгэлзүүлэх тухай, Хорооны 2025 оны тусгай зөвшөөрөлтэй холбоотой баталсан тогтоолын хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай-Тогтоол цуцлах тухай) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны нийт 12 (Тогтоол №12-23, 2026-01-30) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит хуралдааны үеэр нэр бүхий гишүүдээс удаа дараа гарсан санал зөвлөмж болон хорооны даргаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан”-гийн танилцуулгыг тус хорооны бүтцийн нэгж болох ЗУХАГ, Зохицуулалтын газар, РДЗХГ, ЗЗҮТЗГ, Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар, Шуудангийн зохицуулалтын газар тус бүрээр сонсов.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанаар /2025-12-10/ Хорооны 2025 оны 249 тоот “Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай” (Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”) тогтоолыг баталж, энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ХХЗХ-2025 /ДГЗҮ-СШ-04/ тоот “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай зарласан болно. Зохицуулах хорооны 2026 оны ээлжит 02 дугаар хуралдаанаар дээрх сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан Үнэлгээний ажлын хэсгийн ХХЗХ-2025 /ДГЗҮ-СШ-04/ тоот сонгон

шалгаруулалт”-ын үйл ажиллагаа, үнэлгээ гүйцэтгэсэн тайлан тэмдэглэл, холбогдох танилцуулга, үнэлгээний ажлын хэсгийн санал дүгнэлт болон “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” 2 тогтоолын төслийг тус тус авч хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Зохицуулах хорооны даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/294 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 12 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг баталсан. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Эм Жи Эл радио ньус ХХК-ийг “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-д шалгарсанд тооцсугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, Эм Жи Эл радио ньус ХХК-д Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад 88.3МГц-ийн радио давтамж, радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 2031 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, . Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Энэхүү тогтоолын 4 дүгээр заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Зохицуулах хорооны даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/294 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 13 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлан шийдвэрлэв. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Эх элгэн нутаг ХХК-ийг “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-д шалгарсанд тооцсугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, Эх элгэн нутаг ХХК-д Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад 89.1МГц-ийн радио давтамж, радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 2031 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, . Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Энэхүү тогтоолын 4 дүгээр заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд

хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Харилцаа холбооны зохицуулах хороонд үйлчилгээ эрхлэгч нэр бүхий ААН, хуулийн этгээдээс орон нутгийн иргэдэд мэдээ, мэдээлэл, боловсрол, соёл, урлагийн агуулгатай хөтөлбөрүүдийг хүргэх, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, бүс нутгийн хөгжил, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд суманд радио станц ажиллуулах зөвшөөрөл олгох хүсэлтийг ирүүлсэн болно. Энэхүү ирүүлсэн хүсэлтийг тус хорооны РДЗХГ, хуулийн хэлтсээс хамтран судалж үзээд, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн “Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-ийн танилцуулга, баримт бичгийн төсөл, сонгон шалгаруулалтыг зарлах тухай тогтоолын төслийг ажлын хэсгээс боловсруулсан болно. Зохицуулах хорооны 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит 02 дугаар хуралдаанаар Ажлын хэсгийн боловсруулсан дээрх сонгон шалгаруулалтын талаар танилцуулга, ирүүлсэн хүсэлт, ажлын хэсгийн санал, дүгнэлт болон тогтоолын төсөл, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг тус тус хэлэлцээд, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 14 тоот “Сонгон шалгаруулалт зарлах тухай” тогтоолыг баталж шийдвэрлэв. Энэхүү тогтоолын “Тогтоолын 1 дүгээр заалтад, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-ыг 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдөр зарласугай. Тогтоолыг 2 дугаар заалтад, Уг тогтоолын хавсралтаар “Сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг баталсугай. Тогтоолын 3 дугаар заалтад, Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээний ажлын хэсэг байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ. ХХЗХ-ноос 2026 оны 14 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ХХЗХ-ноос ХХЗХ-2026 /ӨГЦЦХБ-СШ-01/ тоот сонгон шалгаруулалтыг 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл зарлаад байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтад байгаа эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хэмжээг тогтоох, дутагдуулсан, бүртгэлгүй орхисон, маргаантай, ашиглалтгүй хөрөнгийн судалгааг гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах; Эд хөрөнгийн дотоодын

тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана (1. үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд хоёр удаа / 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/; 2. түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/) гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хорооны даргын 2025 оны А/287 тоот тушаалаар “ХХЗХ-ны 2025 оны жилийн эцсийн Эд хөрөнгийн тооллогын ажлын хэсэг” байгуулагдан ажиллаж, жилийн эцсийн тооллогоор байгууллагын балансад бүртгэлтэй 15,661,125,677.18 төгрөгийн үндсэн хөрөнгөнд тооллогыг гүйцэтгэн холбогдох хууль тогтоомжийн заалтууд, ажлын хэсгийн санал дүгнэлт, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох тухай” болон “Үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах тухай” танилцуулга, 2 тогтоолын төсөл, тогтоолын хавсралт жагсаалтыг боловсруулж, Хорооны 2025 оны 01 дүгээр сарын ээлжит 02 дугаар хуралдаанд хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийн санал, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох тухай” 15 тоот тогтоолыг 6 хавсралтын хамт батлав. Энэхүү тогтоолд, “Тус хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглалтын хугацаа дууссан ч цаашид хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой хөрөнгүүдийг доорх хавсралтуудад заасны дагуу ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлсүгэй.

1. Нэгдүгээр хавсралтад дурдсан 1 (нэг) нэр төрлийн, нийт 327,600.00 (гурван зуун хорин долоон мянга зургаан зуун) төгрөгийн анхны өртөгтэй барилга байгууламжийн ашиглалтын хугацааг сунгаж, нийт үнийг 234,000.00 (хоёр зуун гучин дөрвөн мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоох;
2. Хоёрдугаар хавсралтад дурдсан 1 (нэг) нэр төрлийн, нийт 245,000,000.00 (хоёр зуун дөчин таван сая) төгрөгийн анхны өртөгтэй тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацааг сунгаж, нийт үнийг 147,000,000.00 (нэг зуун дөчин долоон сая) төгрөгөөр шинэчлэн тогтоох;
3. Гуравдугаар хавсралтад дурдсан 66 (жаран зургаа) нэр төрлийн, нийт 652,078,803.22 (зургаан зуун тавин хоёр сая далан найман мянга найман зуун гурван төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй машин тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг сунгаж, нийт үнийг 314,250,239.23 (гурван зуун арван дөрвөн сая хоёр зуун тавин мянга хоёр зуун гучин есэн төгрөг хорин гурван мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоох;
4. Дөрөвдүгээр хавсралтад дурдсан 66 (жаран зургаа) нэр төрлийн, нийт 239,122,713.26 (хоёр зуун гучин есэн сая нэг зуун хорин хоёр мянга долоон зуун арван гурван төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй оффисын зориулалтын тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг сунгаж, нийт үнийг 153,583,280.25 (нэг зуун тавин гурван сая таван зуун наян гурван мянга хоёр зуун наян төгрөг хорин таван мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоох;
5. Тавдугаар хавсралтад дурдсан 65 (жаран тав) нэр төрлийн, нийт 24,638,334.17 (хорин дөрвөн сая зургаан зуун гучин найман мянга гурван зуун гучин дөрвөн

төгрөг арван долоон мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй тавилга, эд хогшлийн ашиглалтын хугацааг сунгаж, нийт үнийг 7,593,940.50 (долоон сая таван зуун ерэн гурван мянга есэн зуун дөчин төгрөг тавин мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоох;

6. Зургаадугаар хавсралтад дурдсан 18 (арван найм) нэр төрлийн, нийт 281,502,700.63 (хоёр зуун наян нэгэн сая таван зуун хоёр мянга долоон зуун төгрөг жаран гурван мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй програм хангамжийн ашиглалтын хугацааг сунгаж, нийт үнийг 168,901,620.38 (нэг зуун жаран найман сая есэн зуун нэгэн мянга зургаан зуун хорин төгрөг гучин найман мөнгө);

Тогтоолын 2 дугаар заалтад, Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Тус хуралдаанаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийн санал, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах тухай” 16 тоот тогтоолыг 3 хавсралтын хамт батлав. Энэхүү тогтоолд, “Тус хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа дуусаж, цаашид хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй хөрөнгүүдийг доорх хавсралтуудад заасны дагуу акталж данснаас хасах хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлсүгэй.

1. Нэгдүгээр хавсралтад дурдсан 39 (гучин ес) нэр төрлийн, нийт 219,105,585.99 (хоёр зуун арван есөн сая нэг зуун таван мянга таван зуун наян таван төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй машин тоног төхөөрөмж;
2. Хоёрдугаар хавсралтад дурдсан 10 (арав) нэр төрлийн, нийт 22,319,405.82 (хорин хоёр сая гурван зуун арван есөн мянга дөрвөн зуун таван төгрөг наян хоёр мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй оффисын зориулалтын тоног төхөөрөмж;
3. Гуравдугаар хавсралтад дурдсан 1 (нэг) нэр төрлийн, нийт 199,990.00 (нэг зуун ерэн есөн мянга есэн зуун ер) төгрөгийн анхны өртөгтэй тавилга эд хогшил;

Тогтоолын 2 дугаар заалтад, Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Зохицуулах хорооны 2026 оны ээлжит 02 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл олгосноос хойш 2 жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй үйлчилгээ эрхлэгчдийн танилцуулга, хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (ТЗ түдгэлзүүлэх тухай), Хорооны 2025 оны тусгай зөвшөөрөлтэй холбоотой баталсан тогтоолын хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (Тогтоол цуцлах тухай) үнэлгээ, дүгнэлт болон холбогдох ажлын хэсэг, бүтцийн газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 7 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 7 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9

дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 17 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Монгол шуудан ХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх” /Шуудангийн сүлжээ/ 41200001 тоот) 10 жилийн хугацаагаар сунгасан;

- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 18 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдэд 3 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар ((Жи Ар сэйлс хаб ХХК: 1-900-2020, Доктор авто франчайз ХХК: 1-800-1937, Сонгуулийн ерөнхий хороо: 1-800-2800) олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 19 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд олгосон (Төрийн банк ХК: 1-800-1881; Хаан банк ХК: 1-900-1917) 2 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 20 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай (Өгөөмөр уул ХХК, Эсмс мульт коннекшн ХХК: Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) зөвшөөрлийг 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 21 тоот тогтоолыг баталж, тус тогтоолоор тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарсан хэдий ч тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулаагүй, энэхүү тогтоолын хавсралтад (2025 оны 44 тоот тогтоолын 8 дахь хэсэг) заасан Цомбон тоосго ХХК-ийн тусгай зөвшөөрөл олгох тухай тогтоолын хавсралтын холбогдох хэсгийг цуцлав;
- Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 22 тоот тогтоолыг баталж, тус тогтоолоор тусгай зөвшөөрөл сунгах шийдвэр гарсан хэдий ч тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулаагүй, энэхүү тогтоолын хавсралтад (2025 оны 199 тоот тогтоолын 1 дэх хэсэг) заасан Дөлгөөн дэлгэрэх ХХК-ийн тусгай зөвшөөрөл сунгах тухай тогтоолын хавсралтын холбогдох хэсгийг цуцлав;
- Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 23 тоот тогтоолыг баталж, тус хорооны тогтоолоор харилцаа холбооны сүлжээний дугаар олгох шийдвэр гарсан боловч тусгай дугаарын гэрээ байгуулаагүй, энэхүү тогтоолын хавсралтад (2025 оны 52 тоот тогтоолын 1 дэх хэсэг) заасан Альфа интеллиженс ХХК-ийн харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай тогтоолын хавсралтын холбогдох хэсгийг цуцалж тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2026-02-09